



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/134

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2, 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий суманд хэрэгжиж байгаа Үерийн далан байгуулах ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн)


И.Маралмаа (Газрын даамал)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Б.Болормаа (Сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын төлөөлөгч)

2. Ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН